



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/08

Ханх сум

**Орон тооны бус зөвлөлийг татан
буулгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, "Тушаал хүчингүй болгох тухай" Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-нь өдрийн А/20 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/318 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөлийг татан буулгасугай.

2.Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөлийн шийдвэр, хурлын тэмдэглэл, бусад холбогдох баримт материалыг аймгийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлэхийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга, нийгмийн даатгалын байцаагч (Д.Оюунчимэг)-т үүрэг болгосугай.

3."Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөл байгуулах тухай" сумын Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/29 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Баасансүрэн)-д даалгасугай.

ДАРГА  Л. ДАВААБАЯР

